

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **БНА-2026/002/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026 он 1. 27 № 2/55

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 71504 (Газрын зураглал, кадастр) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,509,080.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 1,399,038.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 1,290,668.5 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 108,370.3 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050164

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 122 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ГЗБГЗЗЕГ-аас 92.2 хувьтай үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ



Хоёр: Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)**

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b><u>70,715,492.97</u></b>	<b><u>140,632,445.40</u></b>
<b>АВЛАГА</b>	54,331,525.97	126,100,208.40
Төлбөртэй үйлчилгээний авлага	54,331,525.97	95,910,212.40
Татаас, санхүүжилтийн авлага		30,189,996.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,383,967.00	14,532,237.00
Бэлэн бүтээгдэхүүн	55,346.00	55,346.00
<b>Хангамжийн материал</b>	16,328,621.00	14,476,891.00
Бичиг хэргийн материал	448,050.00	1,121,310.00
Аж ахуйн материал	2,664,500.00	3,151,700.00
Бусад хангамжийн материал	13,216,071.00	10,203,881.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b><u>438,282,311.45</u></b>	<b><u>418,800,839.73</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	438,282,311.45	418,800,839.73
<b>Биет хөрөнгө</b>	349,011,478.26	329,530,006.54
Барилга, байгууламж, орон сууц	195,394,386.72	195,394,386.72
Хуримтлагдсан элэгдэл	-27,645,733.76	-27,645,733.76
Авто-тээврийн хэрэгсэл	172,700,000.00	157,700,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-127,569,444.50	-137,186,111.18
Машин тоног төхөөрөмж (компьютер)	368,166,971.94	395,604,271.94
Хуримтлагдсан элэгдэл	-251,078,891.39	-273,573,258.15
Тавилга, аж ахуйн эд хогшил	39,669,976.12	38,070,476.12
Хуримтлагдсан элэгдэл	-20,625,786.87	-18,834,025.15
<b>Биет бус хөрөнгө</b>	89,270,833.19	89,270,833.19
Програм хангамж	2,350,000.00	1,990,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-840,166.81	-480,166.81
Бусад биет бус хөрөнгө	87,761,000.00	87,761,000.00
<b>Бусад хөрөнгө</b>	0.00	0.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>508,997,804.42</u></b>	<b><u>559,433,285.13</u></b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	30,189,996.00
<b>Өглөг</b>	0.00	30,189,996.00
<b>Бусад өглөг</b>	0.00	30,189,996.00
Хувь хүмүүст төлөх өглөг		30,189,996.00
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	508,997,804.42	529,243,289.13
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	386,538,027.70	386,538,027.70
Өмч: - төрийн	386,538,027.70	386,538,027.70
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	60,629,452.35	80,874,937.06
Өмнөх үеийн үр дүн	60,629,452.35	60,629,452.35
Тайлант үеийн үр дүн		20,245,484.71
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,830,324.37	61,830,324.37
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>508,997,804.42</u></b>	<b><u>529,243,289.13</u></b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>508,997,804.42</u></b>	<b><u>559,433,285.13</u></b>

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,449,333,931.48</b>	<b>1,639,382,950.40</b>
<b>Улсын төсвөөс</b>	1,395,805,253.03	1,474,299,096.00
Урсгал	1,389,361,900.00	1,399,038,796.00
Хөрөнгийн	2,957,217.65	
Бусад төсөвт байгууллагаас	3,486,135.38	75,260,300.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>53,528,678.45</b>	<b>165,083,854.40</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,346,137.45	
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	69,173,642.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,182,541.00	95,910,212.40
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>170,724,216.13</b>	<b>118,422,400.00</b>
<b>Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого</b>	170,724,216.13	118,422,400.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	170,724,216.13	118,422,400.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,724,216.13	118,422,400.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,620,058,147.61</b>	<b>1,757,805,350.40</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,682,893,369.70</b>	<b>1,737,559,865.69</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	1,514,330,453.36	1,541,168,602.26
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,077,970,614.17	1,127,258,654.61
Үндсэн цалин	601,573,206.71	847,603,069.00
Нэмэгдэл	364,547,645.22	214,331,848.55
Унаа хоолны хөнгөлөлт	49,292,027.74	27,367,447.80
Урамшуулал	62,557,734.50	37,956,289.26
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	142,706,628.94	141,027,638.54
Тэтгэврийн даатгал	100,679,593.72	96,243,846.25
Тэтгэмжийн даатгал	10,506,758.80	11,177,553.02
ҮОМШӨ-ний даатгал	5,253,379.40	5,850,396.68
Ажилгүйдлийн даатгал	5,253,379.40	7,181,125.40
Эрүүл мэндийн даатгал	21,013,517.62	20,574,717.19
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>		
<b>Тогтмол зардал</b>	26,021,219.10	32,162,799.87
Гэрэл, цахилгаан	2,494,245.10	3,011,936.87
Түлш, халаалт	20,378,074.00	25,916,495.00
Цэвэр, бохир ус	3,148,900.00	3,234,368.00
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	21,111,246.07	38,519,267.00
Бичиг хэрэг	7,476,307.25	7,589,360.00
Тээвэр, шатахуун	12,909,860.42	17,617,015.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,100.00	724,572.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	449,978.40	
Аж ахуйн материал худалдан авах зардал		5,673,300.00
Бараа материал акталсны зардал		6,915,020.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	14,895,000.00
Багаж, техник, хэрэгсэл		375,000.00
Урсгал засвар		14,520,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	2,688,300.00	17,283,200.00
Дотоод албан томилолт	2,688,300.00	17,283,200.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,024,200.00	14,879,863.16
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,851,300.00	14,879,863.16
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	34,700.00	
Даатгалын үйлчилгээ	94,200.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	234,808,245.08	155,142,179.08
Бараа үйлчилгээний бусад зардал	141,225,549.90	59,718,307.36
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,582,695.18	95,423,871.72

<b>ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	168,562,916.34	196,391,263.43
<b>Бусад</b>	109,774,400.00	67,368,495.92
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,697,200.00	350,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,637,200.00	36,828,499.92
Тэтгэвэрт гархал олгох нэг удаагийн тэтгэмж		30,189,996.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,440,000.00	
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	58,788,516.34	129,022,767.51
Төвлөрүүлэх шилжүүлэг	56,685,176.04	78,180,283.04
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,103,340.30	50,842,484.47
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,682,893,369.70</b>	<b>1,737,559,865.69</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-62,835,222.09</b>	<b>20,245,484.71</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-62,835,222.09</b>	<b>20,245,484.71</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,442,890,578.45</b>	<b>1,522,543,963.97</b>
<b>Улсын төсвөөс</b>	1,389,361,900.00	1,399,038,796.00
Урсгал	1,389,361,900.00	1,399,038,796.00
<b>БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>150,289,381.00</b>	<b>118,422,400.00</b>
<b>Төсөв байгууллагын ажил үйлчилгээний орлого</b>	150,289,381.00	118,422,400.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,289,381.00	118,422,400.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	53,528,678.45	123,505,167.97
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,346,137.45	0.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	69,173,642.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,182,541.00	54,331,525.97
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,593,179,959.45</b>	<b>1,640,966,363.97</b>
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>1,557,265,759.45</b>	<b>1,636,466,363.97</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,388,702,843.11</b>	<b>1,443,757,950.54</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,086,471,268.64	1,130,917,448.36
Үндсэн цалин	557,607,023.01	625,199,692.07
Нэмэгдэл	417,014,483.39	360,650,515.04
Унаа хоолны хөнгөлөлт	49,292,027.74	69,876,289.57
Урамшуулал	62,557,734.50	75,190,951.68
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	134,157,674.47	141,051,694.79
Тэтгэврийн даатгал	92,130,639.25	96,267,902.50
Тэтгэмжийн даатгал	10,506,758.80	11,177,553.02
ҮОМШӨ-ний даатгал	5,253,379.40	5,850,396.68
Ажилгүйдлийн даатгал	5,253,379.40	5,551,168.52
Эрүүл мэндийн даатгал	21,013,517.62	22,204,674.07
<b>Тогтмол зардал</b>	25,808,600.00	30,832,520.87
Гэрэл, цахилгаан	2,281,626.00	3,011,936.87
Түлш, халаалт	20,378,074.00	24,586,216.00
Цэвэр, бохир ус	3,148,900.00	3,234,368.00
<b>Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал</b>	6,372,800.00	11,272,706.00
Бичиг хэрэг	2,080,600.00	3,680,370.00
Тээвэр, шатахуун	3,414,900.00	5,507,814.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,100.00	663,522.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	602,200.00	1,421,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	900,000.00	10,693,450.00
Багаж, техник, хэрэгсэл		1,375,000.00
Урсгал засвар	900,000.00	9,318,450.00
<b>Томилолт, зочны зардал</b>	2,868,300.00	17,283,200.00

Дотоод албан томилолт	2,868,300.00	17,283,200.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,024,200.00	14,879,863.16
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,851,300.00	14,879,863.16
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	34,700.00	0.00
Даатгалын үйлчилгээ	94,200.00	0.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	0.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	123,100,000.00	86,827,067.36
Бараа үйлчилгээний бусад зардал	123,100,000.00	86,827,067.36
<b>ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>168,562,916.34</b>	<b>192,708,413.43</b>
<b>Бусад</b>	109,774,400.00	33,495,649.92
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,697,200.00	350,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,637,200.00	33,145,649.92
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,440,000.00	
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	58,788,516.34	159,212,763.51
Төвлөрүүлэх шилжүүлэг	56,685,176.04	108,370,279.04
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	2,103,340.30	50,842,484.47
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,557,265,759.45</b>	<b>1,636,466,363.97</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>35,914,200.00</b>	<b>4,500,000.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>35,914,200.00</b>	<b>4,500,000.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>35,914,200.00</b>	<b>4,500,000.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	35,914,200.00	4,500,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,914,200.00	4,500,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-35,914,200.00</b>	<b>-4,500,000.00</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	0.00

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	123,464,674.44	571,833,026.51
Тайлант үеийн үр дүн			-62,835,222.09	-62,835,222.09
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>386,538,027.70</b>	<b>61,830,324.37</b>	<b>60,629,452.35</b>	508,997,804.42
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	60,629,452.35	508,997,804.42
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	386,538,027.70	61,830,324.37	60,629,452.35	508,997,804.42
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>386,538,027.70</b>	<b>61,830,324.37</b>	<b>60,629,452.35</b>	508,997,804.42
Тайлант үеийн үр дүн			20,245,484.71	20,245,484.71
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>386,538,027.70</b>	<b>61,830,324.37</b>	<b>80,874,937.06</b>	529,243,289.13

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,509,080,900.00	1,409,090,917.00	99,989,983.00	93.37
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,404,080,900.00	1,269,046,917.00	135,033,983.00	90.38
Урсгал	1,404,080,900.00	1,269,046,917.00	135,033,983.00	90.38
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	21,621,600.00	-21,621,600.00	
Орон нутгийн төсвөөс		21,621,600.00	-21,621,600.00	
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	105,000,000.00	118,422,400.00	-13,422,400.00	112.78
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	105,000,000.00	118,422,400.00	-13,422,400.00	112.78
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000,000.00	118,422,400.00	-13,422,400.00	112.78
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,509,080,900.00	1,409,090,917.00	99,989,983.00	
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,151,736,300.00	1,111,722,304.61	40,013,995.39	96.53
Үндсэн цалин	611,214,100.00	611,056,792.07	157,307.93	99.97
Нэмэгдэл	429,554,400.00	355,598,271.29	73,956,128.71	82.78
Унаа хоолны хөнгөлөлт	54,885,600.00	69,876,289.57	-14,990,689.57	127.31
Урамшуулал	56,082,200.00	75,190,951.68	-19,108,751.68	134.07
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	162,994,500.00	139,792,993.04	23,201,506.96	85.77
Тэтгэврийн даатгал	112,448,600.00	95,009,200.75	17,439,399.25	84.49
Тэтгэмжийн даатгал	12,636,500.00	11,177,553.02	1,458,946.98	88.45
ҮОМШӨ-ний даатгал	6,318,200.00	5,850,396.68	467,803.32	92.60
Ажилгүйдлийн даатгал	6,318,200.00	5,551,168.52	767,031.48	87.86
Эрүүл мэндийн даатгал	25,273,000.00	22,204,674.07	3,068,325.93	87.86
Тогтмол зардал	23,357,300.00	22,829,178.87	528,121.13	97.74
Гэрэл, цахилгаан	2,974,200.00	3,011,936.87	-37,736.87	101.27
Түлш, халаалт	17,470,600.00	17,226,858.00	243,742.00	98.60
Цэвэр, бохир ус	2,912,500.00	2,590,384.00	322,116.00	88.94
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	147,900.00	0.00	147,900.00	0.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	147,900.00		147,900.00	0.00
Бусад бараа үйлчилгээний зардал	3,669,800.00	3,001,902.00	667,898.00	81.80
Бичиг хэрэг	1,247,100.00	898,600.00	348,500.00	72.06
Тээвэр, шатахуун	317,100.00	317,080.00	20.00	99.99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448,800.00	302,022.00	146,778.00	67.30
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	448,600.00	276,000.00	172,600.00	61.52
Дотоод албан томилолт	833,200.00	833,200.00	0.00	100.00
Багаж, техник, хэрэгсэл	375,000.00	375,000.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,763,600.00	11,421,821.16	1,341,778.84	89.49
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,416,800.00	11,421,821.16	-5,021.16	100.04
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	134,400.00		134,400.00	0.00
Даатгалын үйлчилгээ	666,400.00		666,400.00	0.00
Тээврийн хэрэгслийн татвар	546,000.00		546,000.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	85,683,700.00	86,827,067.36	-1,143,367.36	101.33
Бараа үйлчилгээний бусад зардал	85,683,700.00	86,827,067.36	-1,143,367.36	101.33
<b>ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	68,727,800.00	33,495,649.92	35,232,150.08	48.74
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	68,727,800.00	33,495,649.92	35,232,150.08	48.74

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	350,000.00	350,000.00	0.00	100.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,913,400.00		32,913,400.00	0.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	35,464,400.00	33,145,649.92	2,318,750.08	93.46
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,509,080,900.00</b>	<b>1,409,090,916.96</b>	<b>99,989,983.04</b>	<b>93.37</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,080,900.00	1,409,090,916.96	99,989,983.04	93.37
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,353,100.00	1,375,595,267.04	64,757,832.96	95.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>123,505,167.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>123,505,167.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	72,662,683.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	19,195,143.75
210101	Үндсэн цалин	14,142,900.00
210102	Нэмэгдэл	5,052,243.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,258,701.75
210201	Тэтгэврийн даатгал	1,258,701.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,003,342.00
210302	Түлш, халаалт	7,359,358.00
210303	Цэвэр, бохир ус	643,984.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,479,004.00
210401	Бичиг хэрэг	2,781,770.00
210402	Тээвэр, шатахуун	5,190,734.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	361,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,145,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,818,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00
210604	Урсгал засвар	9,318,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	16,450,000.00
210702	Дотоод албан томилолт	16,450,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,458,042.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,458,042.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	50,842,484.47
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	50,842,484.47
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>50,842,484.47</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	50,842,484.47
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	123,505,167.97
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	123,505,167.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,173,642.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,331,525.97

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 68.2 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

### **Залруулсан алдаа:**

1. Байгууллагын даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/37 дугаар тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон 6,915.0 мянган төгрөгийн бараа материалыг актлах шийдвэр гарсан байхад 68.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” , 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалт, УСНББОУС-12 Бараа материал, НББОУС-2 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 488,320,2 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, бусад хууль тогтоомжийн 1 зөрчилд зөвлөмж өгч, 488,320.2 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 488,320,2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааны 479,307.9 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал тул материаллаг бусаар тооцсон, аудитаар илэрсэн 9,012.3 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **3.1. Албан шаардлага**

1. Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 425,270.5 мянган төгрөгийн 5 гүйлгээ, байгууллагын даргын 29,000.0 мянган төгрөгийн 10 тушаалыг байршуулаагүй, тодотгосон төсвийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт”, 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллүүдийг нөхөн байршуулж, зөрчлийг арилгах

2. Байгууллагын албан хаагчдад 10 дугаар сард олгосон 1,994.7 мянга, 11 дүгээр сард олгосон 10.0 мянга, Шинэжинст сумын газрын даамалд олгосон 1,539.6 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд мэдээлээгүй, 2 албан хаагчийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1 хувиар буюу 698.1 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2 дахь "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" заалт, УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Үнэлгээ ба хуваарилалт, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин зөрүүтэй мэдээлсэн нэр бүхий албан хаагчдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг залруулж зөрчлийг арилгах

3. Байгууллагын дарга таван сумын ЗДТГ-ын даргатай гэрээ байгуулж, захиалагчийн хяналтын зардлын төлбөрт 25,037.4 мянган төгрөгийг оруулахаар гэрээ байгуулсан байхад оны эцэст гэрээг дүгнээгүй, гэрээний төлбөрийг тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, байгууллагын даргын байгуулсан барилгын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээний 5.1.1 дэх "Ерөнхий захиалагч хяналт хийх гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний төлбөр болох ..... төгрөгийг Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын Төрийн сан банкны дансанд ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ" гэсэн заалт, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Нийцсэн бөгөөд зохистой, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах

4. Албан хаагчдад томилолтын урьдчилгаа олгохдоо өглөгөөр бүртгэсэн, томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 10, 12 дугаар сарын 4,770.0 мянган төгрөгийн зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зардлыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-

санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Нийцсэн бөгөөд зохистой, Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын хуудаст тавих дотоод хяналтыг сайжруулах

### **3.2. Зөвлөмж**

Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, 12-28 БНР улсын дугаартай, Toyota Prius 20 маркийн суудлын автомашиныг 2025 оны техникийн улсын үзлэгт оруулаагүй байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам”-ын 4.3 дахь “Иргэн, хуулийн этгээд нь нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийг хагас жил тутамд, бусад тээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулах үүрэгтэй” гэсэн заалт, Нийцсэн бөгөөд зохистой, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах

**Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/37 дугаар тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй болсон 6,915.0 мянган төгрөгийн бараа материалыг актлах шийдвэр гарсан байхад 68.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан байна.	1	68.2			1	68.2	1	68.2				
ДҮН	1	68.2	0	-	1	68.2	1	68.2	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын албан хаагчдад 10 дугаар сард олгосон 1,994.7 мянга, 11 дүгээр сард олгосон 10.0 мянга, Шинэжинст сумын газрын даамалд олгосон 1,539.6 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд мэдээлээгүй, 2 албан хаагчийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 1 хувиар зөрүүтэй мэдээлсэн байна.	1	4242.3			1	4242.3						

Албан хаагчдад томилолтын урьдчилгаа олгохдоо өглөгөөр бүртгэсэн, томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад 10, 12 дугаар сарын 4,770.0 мянган төгрөгийн зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зардлыг олгосон байна.	1	4,770.0			1	4,770.0						
Дүн	2.00	9,012.30	-	-	2.00	9,012.30	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 425,270.5 мянган төгрөгийн 5 гүйлгээ, байгууллагын даргын 29,000.0 мянган төгрөгийн 10 тушаалыг байршуулаагүй байна.	1	454,270.5			1	454,270.5		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>454,270.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>454,270.5</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй суудлын автомашиныг 2025 оны техникийн улсын үзлэгт оруулаагүй байна.	1	0					1	0
Байгууллагын дарга, 5 сумын ЗДТГ-ын даргатай гэрээ байгуулж, захиалагчийн хяналтын зардлын төлбөрт 25,037.4 мянган төгрөгийг оруулахаар гэрээ байгуулсан байхад гэрээг дүгнээгүй, гэрээний төлбөрийг тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	25037.4			1	25,037.4		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>25,037.40</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>25,037.40</b>	<b>1</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>479,307.90</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>479,307.90</b>	<b>1</b>	<b>0</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

---oOo---